

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 05 дугаар сарын 30

Улаанбаатар хот

	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
	<p>Үүрэг даалгавар НЭГ: “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийн нэгдсэн арга хэмжээг сайтар зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах. Үүнд: 1. Иргэд, олон нийтийн амгалан тайван байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хэв журмыг сахиулах; 2. Хүүхдүүдээ гэнэтийн осол эндэгдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хүргэх; 3. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалд сайтар хяналт тавих; 4. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайтар хангах; 5. Амралтын өдрүүдэд хүүхэд багачууд, залуучууд, гэр бүлээр чөлөөт цагаа тав тухтай, өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлж, соёл урлаг, үзвэр үйлчилгээг нэмэгдүүлэх;</p>			
1	<p>Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан дүүргийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/143 тоот захирамжаар Ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу баярын арга хэмжээг дүүргийн Тусгаар тогтнолын талбайд 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулан, дүүргийн 1-24 дүгээр хороодын зорилтот бүлгийн 2350, хөгжлийн бэрхшээлтэй 500 хүүхэд гарын бэлэг гардуулан өглөө. Баярын арга хэмжээ тус өдрийн 11:00-17:00 цагийн хооронд зохион байгуулагдан хүүхэд багачууд, залуучууд, гэр бүлээрээ чөлөөт цагаа тав тухтай, өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлж, соёл урлаг, үзвэр үйлчилгээгээр ханган ажиллалаа. Үүнд: Худалдаа үйлчилгээ-10, хоол худалдаа-4, тоглоом-14 нийт 28 асар, майханд үйлчилгээ үзүүлсэн.</p> <p>Хамгаалалтын төлөвлөгөө, ажил үүргийн хуваарийн дагуу тус газрын харьяа хоёрдугаар хэлтсээс “Тусгаар тогтнолын талбай”-д өдөр, оройн ээлжээр 5 чиглэлд 10 алба хаагч явган эргүүл, халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлд 2 алба хаагч, нийт 24 алба хаагчид ажиллаж, төөрсөн 6 хүүхдийг хүлээлгэн өгч, 167 ширхэг бугуйвч тараасан.</p> <p>Дүүргийн Цагдаагийн нэгдүгээр хэлтсээс Жанжин Д.Сүхбаатарын талбайн баруун тал буюу дүүргийн 1, 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 5 чиглэлд 10 алба хаагч 2 ээлжээр, нийт 20 алба хаагчид төөрсөн 11 хүүхдийг ар гэрт нь хүлээлгэн өгч, 389 ширхэг бугуйвч, дүүргийн 1 дүгээр хороонд байрлах Улсын Их Дэлгүүрийн урд</p>			90

	<p>талбай орчим 3 чиглэлд 6 алба хаагчид 2 ээлжээр, нийт 12 алба хаагчид ажиллаж, төөрсөн 12 хүүхдийг хүлээлгэн өгч, 127 ширхэг бугуйвч тус тус тараан ажилласан. Дүүргийн Замын цагдаагийн хэлтсээс хариуцсан дүүргийн нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр нийт 15 алба хаагч 2 ээлжээр үүрэг гүйцэтгэн ажилласан ба тус газраас нийт явган эргүүлд 56, хөдөлгөөн зохицуулах чиглэлээр 15 алба хаагчид гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эргүүлийн үүрэг гүйцэтгэж, төөрсөн байдалтай нийт 29 хүүхдийг эцэг, эх асран хамгаалагчид хүлээлгэн өгч, бага насны хүүхэд аливаа байдлаар хохирч, гэмтэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 683 ширхэг бугуйвчийг тараах ажлыг зохион байгуулан ажилласан.</p>			
<p>Үүрэг даалгавар ХОЁР: Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлаа бүх шатандаа эрчимжүүлж, авто зам, явган болон дугуйн зам, тохижилт, ногоон байгууламж, барилга байгууламжийн ажлаа гэрээний үндсэн дээр гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж ажиллах.</p>				
2	<p>1.Дүүрэгт Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 он дамжин хэрэгжиж байгаа 146,923.1 сая төгрөгийн нийт 43 төсөл, арга хэмжээ байна. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжих 300.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ, 2022-2023 он дамжин хэрэгжих 39,632.98 сая төгрөгийн нийт 10 төсөл арга хэмжээ, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд шинээр хэрэгжих 1,200.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ, 2022-2023 он дамжих хэрэгжих 865 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ байна. Улс, нийслэл, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтын нийт 59 төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаагаас:</p> <ul style="list-style-type: none"> • Бэлтгэл ажил хийгдэж байгаа 8 төсөл арга хэмжээ: • Тендерийн шатандаа байгаа 9 төсөл арга хэмжээ: • Гэрээ байгуулах шатандаа байгаа 2 арга хэмжээ: • Гэрээ байгуулагдан ажил хийгдэж байгаа 20 төсөл арга хэмжээ: <p>Ажил 100 хувь дууссан 20 төсөл арга хэмжээ тус тус байна. Дүүргийн 10 дугаар хороонд “Цагаан байрны хойд уулзвараас далан дагаад Хүчит шонхор захын уулзвар хүртэлх авто зам”-ын ажлын нөлөөлөлд өртсөн 5 иргэний газар, эд хөрөнгийг дүүргийн төсвийн хөрөнгөөр чөлөөлүүлэн ажиллаж байна.</p> <p>2.Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2023 онд шинээр хэрэгжих 6,605.90 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээ, 2022-2023 он дамжин хэрэгжих 12,590,58 сая төгрөгийн 47 төсөл, арга хэмжээ байгаагаас:</p> <ul style="list-style-type: none"> • Тендерийн шатандаа байгаа 5 төсөл, арга хэмжээ • Гэрээ байгуулагдан ажил хийгдэж байгаа 18 төсөл, арга хэмжээ • Ажил 100 хувь хийгдэж дууссан 31 төсөл арга хэмжээ байна. <p>Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд шинээр хэрэгжих 1,492.02 сая төгрөгийн 24 төсөл, арга хэмжээ, 2022-2023 он дамжин хэрэгжих 526,70 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээ байгаагаас:</p>			90

	<ul style="list-style-type: none"> Тендерийн шатандаа байгаа 14 төсөл, арга хэмжээ Гэрээ байгуулах шатандаа 3 төсөл, арга хэмжээ Гэрээ байгуулагдан ажил хийгдэж байгаа 8 төсөл, арга хэмжээ <p>Ажил 100 хувь хийгдэж дууссан 10 төсөл арга хэмжээ байна.</p>			
Үүрэг даалгавар ГУРАВ: Хөрөнгө оруулалтын цахим системийн нэмэлт хөгжүүлэлт болон хөрөнгө оруулалтын дашбоардад холбох ажлыг эрчимжүүлж, хэрэгжилтийн мэдээллийг тогтмол 7 хоног бүр байршуулж хэвшүүлэх.				
3	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын Мэдээллийн технологийн хэлтсийн мэргэжилтэнтэй /Ахлах мэргэжилтэн С.Соёмботой 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Утас:88119897/ холбогдон Хөрөнгө оруулалтын цахим системийн нэмэлт хөгжүүлэлтийн талаар мэдээлэл авч, дүүргийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн мэдээллийг оруулах албан хаагчдын овог нэр, албан тушаал, цахим хаягийн мэдээллийг өгсөн.			70
Үүрэг даалгавар ДӨРӨВ: Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал асуулгын ажлыг эрчимжүүлж, хороодын Засаг дарга, албан хаагчдыг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж, иргэд, олон нийтийг идэвхтэй оролцуулах ажлыг сайтар зохион байгуулах.				
4	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал асуулгыг дүүргийн 1-24 дүгээр хороонд зохион байгуулан өдөр бүр саналын явцын тайланг авч нэгтгэн ажиллаж байна. Гар утасны аппликейшн ашиглаж чадахгүй өндөр настан болон эмзэг бүлгийн иргэдээс цаасаар санал авах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд нийт 22,000 саналын хуудас хэвлүүлэн хороодод тараан цаасаар санал авах ажлыг зохион байгуулж байна. 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар цахимаар нийт 4224 санал авсан. Дүүргийн “Чингэлтэй дүүрэг/Chingeltei District” facebook цахим хуудсаар болон хороодын цахим хаягаар иргэд олон нийтэд мэдээ, мэдээллээр ханган ажиллаж байна.			70
Үүрэг даалгавар ТАВ: Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэртээ ногоон байгууламжууд болон нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлж цэцэгжүүлэх, зүлэгжүүлэх, тохижилт, хог хаягдлыг цэвэрлэх, тээвэрлэх ажлуудаа эрчимжүүлж ажиллах.				
5	Дүүргийн ногоон байгууламжийн арчлалт хамгаалалт, цэнэг усалгааг дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК хариуцан ажилладаг ба нийт 72857м2 талбайн цэвэрлэгээ арчилгааг өдөр тутамдаа хариуцан 138 рейсээр 1380 тонн усаар хаврын цэнэг усалгаа, мод бутны ургалт сайжруулах зорилгоор 863 ширхэг мод, бутны тогоо, 220 у/м ургамлан хашлаганд шуудуу гарган, 233 ширхэг модыг шохойдож ажилласан.			90
Үүрэг даалгавар ЗУРГАА: Хот, нийтийн аж ахуйн ажил үйлчилгээг нийслэл, дүүргийн хэмжээнд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах төлөвлөгөөг 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор баталж, хэрэгжилтийг шуурхай хангаж ажиллах				
6	Дүүргийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/136 дугаар захирамжаар Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх асуудлыг дүүргийн хэмжээнд			70

	судалж санал, дүгнэлт боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт Хот, нийтийн аж ахуйн чиглэлээр хувийн хэвшлийн 3 байгууллага дүүрэгтэй хамтран ажиллаж байна. Үүнд: Айл өрх аж ахуй нэгж байгууллагын Хог цуглуулалт, тээвэрлэлтийн үйлчилгээ, Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ, гэрэлтүүлгийн арчлалт хамгаалалт, засвар үйлчилгээ зэрэг ажлуудыг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.			
Үүрэг даалгавар ДОЛОО: “Улаанбаатар марафон 2023” өдөрлөгийн бэлтгэл ажлыг сайтар хангаж, байгууллагынхаа ажилтан, албан хаагчдыг идэвхтэй хамруулж оролцуулах.				
7	“Улаанбаатар марафон 2023” Олон улсын марафон гүйлтэд дүүргийн иргэд болон хороод, сургууль, цэцэрлэг, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуй нэгж байгууллагуудыг өргөнөөр хамруулж байна. 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар 70 байгууллагын 930 хүн 5000 метр гүйх энгэрийн номер, дугаараа баталгаажуулж аваад байна.			90
Үүрэг даалгавар НАЙМ: Нийслэлийн хэмжээнд амны хөндийн эрүүл мэндийг дээшлүүлэхэд зорилтын хүрээнд “Шүд” төслийн хэрэгжилтийг анхаарч, танилцуулах.				
8	Эрүүл мэндийн яам, дүүргийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Эрүүл мэндийн төв, Мишээл кидс сан хамтран 2023 оны 05 сарын 22-27-ны өдрүүдэд “Явуулын шүд”-ний эмнэлгээр дүүргийн 7, 10, 12, 16,17,18 дугаар хороодын гэр хорооллын зорилтот бүлгийн нийт 420 хүүхдэд үнэ төлбөргүй шүдний үзлэг, эмчилгээнд хамруулан ажилласан. Хүүхдийн салбар амбулаториос дүүргийн 72 дугаар сургуулийн 2000 хүүхдүүдийн амны хөндий болон урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулан эрүүлжилтийн ажлыг зохион байгуулсан. Ахлах болон дунд ангийн сурагчдад хийсэн амны хөндийн эрүүл ахуйн үзлэгээр 38.3% шүдний цооролтой байна. Үүнээс: 1-2 шүд цоорсон 77.5%, 3-4 шүд цоорсон 22%, 5-аас дээш шүд цоорсон 3.8% байна. Япон Улсын Эрүүл хотуудыг дэмжигч ашгийн бус байгууллагатай хамтран дүүргийн Ерөнхий боловсролын 37, 50 дугаар сургуулийн сурагчдын шүдний цоорол, амны хөндийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үзлэгийн тогтолцоог бий болгох зорилго бүхий төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Уг төслийн хүрээнд 2022 оны 9 сард дээрх сургуулиудын амны хөндийн цогц үзлэгийг зохион байгуулж нийт 5000 сурагчийг хамруулан эцэг эх, сурагчдаас амны хөндийн эрүүл ахуйн мэдлэг, дадлын судалгаа явуулж, сурагчдад оо, сойз өгч, сурагч бүрийн амны хөндийн эрүүл мэндийн байдлыг бүртгэлжүүлсэн. Цаашид 2023 онд уг төслийг хэрхэн үргэлжлүүлэх талаар ажлын хэсэг 2023 оны 3 сард цахимаар хуралдан 2023 оны 9-11 дүгээр сард Ерөнхий боловсролын 37 болон 50 дугаар сургуулийн 5000 сурагчдын амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах зорилгоор шүдийг эрдэсжүүлэх, фторт түрхлэх түрхэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр шийдвэрлэн бэлтгэл ажлыг хангаж байна. Энэ хүрээнд ЧДЗДТГ, ЭМТ-ийн хамтарсан баг 2023 оны 6 дугаар сард Япон улсад туршлага			90

	судлах ба Жайка ОУБ болон Япон Улсын Эрүүл хотуудыг дэмжигч ТББ-уудын шүд, амны хөндийн төвүүдийн туршлагыг судалж 5 өдрийн практик сургалтад хамрагдана.			
Үүрэг даалгавар ЕС: Гарааш буулгаж чөлөөлсөн тухай нарийвчилсан тоон мэдээллийг гаргаж танилцуулж, чөлөөлсөн талбайг тохижуулах, нийтийн эзэмшилд бүртгэх ажлуудаа эрчимжүүлж, хэрэгжилт үр дүнг олон нийтэд тогтмол мэдээлж ажиллах.				
9	Нийслэлийн Засаг даргын “Газрын зөрчил арилгах талаар авах зарим арга хэмжээний тухай” 2023 оны А/321 дүгээр захирамж, дүүргийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн “Газрын зөрчил арилгах Дэд ажлын хэсэг байгуулах тухай” А/124 дүгээр захирамжийн хүрээнд 5 байршилд 30 тоосгон гараашийг бүрэн чөлөөлж, гүйцэтгэл 103 хувьтай байна.			90
Үүрэг даалгавар АРАВ: Нийслэлийн хэмжээнд 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах.				
10	2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн дотор боловсруулан хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.			90
Үүрэг даалгавар АРВАН НЭГ: Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гэрэлтүүлгийн асалтад анхаарч, цаашид гэрэлтүүлэг, хяналтын камерыг нэмэгдүүлэх чиглэл тооцоо судалгаа хийж танилцуулах.				
11	Дүүргийн гэрэлтүүлгийн ашиглалт, үйлчилгээ хариуцсан Соёндрийм ххк-тай хамтран сар бүр үзлэг шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд 125 гэрэлтүүлэг, дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр 120 гэрэлтүүлгийг тус тус шинээр хийж гүйцэтгэж байна.			90
Үүрэг даалгавар АРВАН ХОЁР: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгахтай холбогдуулан дүүргүүдэд хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлууд болон хийгдэхээр төлөвлөсөн ажлуудын талаарх илтгэх хуудас, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналуудыг нэгтгэж Нийслэлийн Засаг дарга 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор танилцуулах.				
12	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2 дах хэсэгт заасныг тус тус хэрэгжүүлэхтэй холбогдуулан 2023 онд батлагдсан төсөл, арга хэмжээний явцын мэдээлэл болон дуусаагүй төсөл арга хэмжээний жагсаалтыг нэгтгэн илтгэх хуудасны хамт 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 2/1426 тоот албан бичгээр Нийслэлийн засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн.			90

ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Л.БАЯРМАА

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА Н. НАРАНЗУЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Э.ХУЛАН

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Х.ТУЯА